



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 116 ДУГААР СУРГУУЛИЙН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/41/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261885 Цахим хаяг: [serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)  
Аудитор: Д.Зэндмэнэ  
Утас: 261628 Цахим хаяг: [zendmened@audit.gov.mn](mailto:zendmened@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Лидер экаунт аудит” ХХК-ийн  
захирал П.Шаравхорол  
Утас: 88472789 Цахим хаяг: [leaderaudit.20@gmail.com](mailto:leaderaudit.20@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан .....	15
3.1 Ерөнхий зүйл .....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Материаллаг байдал .....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	17
3.7 Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	18
3.8 Аудитын гол асуудал .....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
3.10 Завсарын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	24

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 116 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Э.НҮРЗЭД ТАНАА

2022.02.24 № 07/332  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 81,125.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Үнэн зөв”, “Толилуулга ба тодруулга”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>89,213,260.95</b>	<b>88,790,875.96</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>938,196.42</b>	<b>2,244,882.00</b>
33100	Татвар, НДШ-ийн авлага	938,196.42	69,901.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	69,901.00
33500	Бусад авлага	-	2,105,080.00
	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>1,150,000.00</b>	<b>1,150,000.00</b>
34700	Урьдчилж гарсан зардал	1,150,000.00	1,150,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	1,150,000.00	1,150,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	1,150,000.00	1,150,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>87,125,064.53</b>	<b>85,395,993.96</b>
35100	Түүхий эд материал	14,805,100.45	11,413,843.91
35110	Тусгай зориулалтын материал	12,026,779.45	8,411,262.91
35130	Эм боох материал	2,778,321.00	3,002,581.00
35400	Хангамжийн материал	72,319,964.08	73,982,150.05
35410	Бичиг хэргийн материал	7,196,620.00	4,150,196.00
35420	Аж ахуйн материал	50,815,430.87	29,022,752.85
35440	Түлш, шатах тослох материал	947,815.00	2,092,972.50
35450	Барилгын засварын материал	1,378,510.00	836,020.00
35460	Хүнсний материал	5,321,976.81	29,764,794.30
35470	Бусад хангамжийн материал	6,659,611.40	8,115,414.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>2,250,472,338.89</b>	<b>2,095,386,871.82</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,250,472,338.89</b>	<b>2,095,386,871.82</b>
39200	Биет хөрөнгө	2,241,859,979.59	2,089,898,410.28
39201	Барилга байгууламж	1,821,494,460.66	1,821,494,460.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(154,218,331.64)	(229,560,434.96)
39203	Авто тээврийн хэрэгсэл	227,015,468.00	227,015,468.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(134,168,648.20)	(155,594,837.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	744,275,097.41	536,722,256.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(574,871,660.15)	(391,813,470.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	208,249,000.03	156,916,998.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(123,151,131.06)	(103,897,269.47)
39217	Номын фонд	227,235,724.54	228,615,239.66
39300	Биет бус хөрөнгө	8,612,359.30	5,488,461.54
39301	Програм хангамж	25,151,025.00	7,935,188.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,538,665.70)	(2,446,726.46)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>2,339,685,599.84</b>	<b>2,184,177,747.78</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>10,667,687.59</b>	<b>44,911,121.42</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,667,687.59</b>	<b>44,911,121.42</b>
41300	Өглөг	10,667,687.59	44,911,121.42
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,667,687.59	44,808,721.42

41311	Цалингийн өглөг		13,117,923.96
41312	НДШ-ийн өглөг		21,023,109.87
41313	ХХОАТ-ын өглөг	9,457,843.59	9,457,843.59
41314	ҮЭ-ийн өглөг	1,209,844.00	1,209,844.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	102,400.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>2,329,017,912.25</b>	<b>2,139,266,626.36</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,329,017,912.25</b>	<b>2,139,266,626.36</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	888,053,349.02	888,053,349.02
51200	Хуримтлагдсан үр дүн	(191,977,369.79)	(346,810,069.54)
51210	Өмнөх үеийн үр дүн	(217,100,185.59)	(157,142,303.65)
51220	Тайлант үеийн үр дүн	25,122,815.80	(189,667,765.89)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,632,941,933.02	1,598,023,346.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН(VI=IV+V)</b>	<b>2,339,685,599.84</b>	<b>2,184,177,747.78</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,597,169,855.91</b>	<b>1,351,725,454.52</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>222,365,655.91</b>	<b>34,649,261.52</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	222,365,655.91	34,649,261.52
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	30,000.00	-
120041	Үндсэн үйл ажиллагаа орлого	30,000.00	-
1220	Тусламжийн орлого	222,193,555.91	34,649,261.52
122001	Хандав тусламж /дотоод/	222,193,555.91	34,649,261.52
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,374,804,200.00</b>	<b>1,317,076,193.00</b>
1310	Улсын төсвөөс	1,374,209,200.00	1,316,446,800.00
131006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,374,209,200.00	1,316,446,800.00
1311	Нэмэлт санхүүжилт	595,000.00	629,393.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	595,000.00	629,393.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1,571,988,460.11</b>	<b>1,521,002,889.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,571,988,460.11</b>	<b>1,521,002,889.45</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,446,702,993.08	1,500,981,284.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,028,113,594.00	1,048,795,823.96
210101	Үндсэн цалин	614,353,850.00	640,093,731.84
210102	Нэмэгдэл	339,321,875.00	327,727,686.12
210104	Урамшуулал	74,437,869.00	80,974,406.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,114,201.58	156,574,506.29
210201	Тэтгэврийн даатгал	80,788,268.58	116,689,106.29
210202	Тэтгэмжийн даатгал	10,375,330.00	9,011,299.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,510,191.00	8,965,489.54
210204	Ажилгүйдлийн даатгал	1,398,139.00	1,965,911.12
210205	Эрүүл мэндийн даатгал	19,042,273.00	19,942,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,457,809.00	35,439,599.66
210301	Гэрэл, цахилгаан	7,325,469.00	8,093,419.00
210302	Түлш, халаалт	18,620,976.00	20,547,000.14
210303	Цэвэр, бохир ус	4,511,364.00	6,799,180.52
2104	Хангамж, бараа материалын зардал	12,296,849.80	47,214,285.46
210401	Бичиг хэрэг	2,354,140.00	3,146,190.00
210402	Тээвэр, шатахуун	2,435,585.00	4,479,442.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,348,916.00	2,018,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	736,560.00	732,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,199,100.00	4,120,786.40
210408	Бараа материал актласны зардал	2,222,548.80	32,717,566.56
2105	Нормативт зардал	31,203,171.70	31,150,219.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	414,416.00	900,200.00
210502	Хоол, хүнс	30,788,755.70	30,250,019.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,253,470.00	6,241,340.00



Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	2,253,470.00	6,241,340.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,521,248.00	4,380,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,772,700.00	2,474,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	352,098.00	297,540.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	276,450.00	488,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	205,742,649.00	171,184,769.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,600.00	2,229,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	205,670,049.00	168,954,969.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,285,467.03	20,021,605.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,884,931.00	4,059,581.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,086,119.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,798,812.00	4,059,581.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	64,400,536.03	15,962,024.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,805,536.03	15,485,024.34
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	595,000.00	477,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>25,181,395.80</b>	<b>(169,277,434.93)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	<b>139,802.00</b>
<b>14</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	-	139,802.00
140	Төсөвт байгууллагын орлого	-	139,802.00
140020	Дансны орлого	-	139,802.00
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	<b>20,530,132.96</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	20,530,132.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсны гарз	-	20,530,132.96
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>25,181,395.80</b>	<b>(189,667,765.89)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	888,053,349.02	1,632,941,933.02	(217,242,285.59)	<b>2,303,752,996.45</b>
4	Тайлант үеийн үр дүн			25,181,395.80	<b>25,181,395.80</b>
3	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>888,053,349.02</b>	<b>1,632,941,933.02</b>	<b>(192,060,889.79)</b>	<b>2,328,934,392.25</b>
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			34,918,586.14	<b>34,918,586.14</b>
5	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	888,053,349.02	1,632,941,933.02	(157,142,303.65)	<b>2,363,852,978.39</b>
6	Үндсэн хөрөнгө дахин үнэлгээний өсөлт бууралт		(34,918,586.14)		<b>(34,918,586.14)</b>
7	Тайлант үеийн үр дүн			(189,667,765.89)	<b>(189,667,765.89)</b>
8	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>888,053,349.02</b>	<b>1,598,023,346.88</b>	<b>(346,810,069.54)</b>	<b>2,139,266,626.36</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,374,834,200.00</b>	<b>1,317,076,193.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>30,000.00</b>	-
1200	Нийтлэг татварын бус орлого	30,000.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	30,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	30,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,374,804,200.00</b>	<b>1,317,076,193.00</b>
1310	Улсын төсвөөс	1,374,209,200.00	1,316,446,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,374,209,200.00	1,316,446,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	595,000.00	629,393.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	595,000.00	629,393.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,364,676,200.00</b>	<b>1,316,390,915.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,364,676,200.00</b>	<b>1,316,390,915.00</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,225,732,913.97	1,264,614,375.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,028,113,594.00	1,036,657,900.00
210101	Үндсэн цалин	614,353,850.00	635,070,758.84
210102	Нэмэгдэл цалин	339,321,875.00	320,612,735.16
210104	Урамшуулал	74,437,869.00	80,974,406.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,052,398.00	134,613,200.00
210201	Тэтгэврийн даатгал	81,726,465.00	94,727,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,375,330.00	9,011,299.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,510,191.00	8,965,489.54
210204	Ажилгүйдлийн даатгал	1,398,139.00	1,965,911.12
210205	Эрүүл мэндийн даатгал	19,042,273.00	19,942,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,457,809.00	35,439,599.66
21301	Гэрэл, цахилгаан	7,325,469.00	8,093,419.00
21302	Түлш халаалт	18,620,976.00	20,547,000.14
210303	Цэвэр, бохир ус	4,511,364.00	6,799,180.52
2104	Хангамж, бараа материалын зардал	12,698,786.00	13,686,500.00
210401	Бичиг хэрэг	1,642,300.00	1,819,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,383,400.00	5,624,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,348,916.00	2,018,200.00
210404	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	818,060.00	732,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,506,110.00	3,492,600.00
2105	Нормативт зардал	11,158,738.97	27,379,056.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,134,000.00	2,444,993.00
210502	Хоол, хүнс	9,694,738.97	23,089,063.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	330,000.00	1,845,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,091,140.00	5,184,600.00
210604	Урсгал засвар	3,091,140.00	5,184,600.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,995,848.00	4,559,340.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	7,247,300.00	2,653,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	352,098.00	297,540.00
210807	Тээврийн хэрэгслийн татвар	276,450.00	488,800.00
210808	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,164,600.00	7,094,180.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	798,600.00	3,405,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,366,000.00	3,688,580.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,943,286.03	51,776,539.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,542,750.00	35,744,614.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	69,901.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,657,819.00	31,615,132.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,086,119.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,798,812.00	4,059,581.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	64,400,536.03	16,031,925.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,805,536.03	15,554,925.34
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	595,000.00	477,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>10,158,000.00</b>	<b>685,278.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>139,802.00</b>
140	Төсөвт байгууллагын орлого	-	139,802.00
140020	Дансны орлого	-	139,802.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>10,158,000.00</b>	<b>825,080.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,158,000.00</b>	<b>825,080.00</b>
223	БУСАД ХӨРӨНГӨ	10,158,000.00	825,080.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,158,000.00	825,080.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(10,158,000.00)</b>	<b>(685,278.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
<b>10</b>	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,316,446,800.00</b>	<b>1,300,961,775.66</b>	<b>15,485,044.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,316,446,800.00</b>	<b>1,300,961,775.66</b>	<b>15,485,024.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,268,681,000.00</b>	<b>1,300,961,775.66</b>	<b>3,393,937.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,037,134,900.00</b>	<b>1,037,134,900.00</b>	-
210101	Үндсэн цалин	623,032,300.00	635,070,758.84	(12,038,458.84)
210102	Нэмэгдэл цалин	336,849,900.00	321,089,735.16	15,760,164.84
210104	Урамшуулал	77,252,700.00	80,974,406.00	(3,721,706.00)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>134,613,200.00</b>	<b>134,613,200.00</b>	-
210201	Тэтгэврийн даатгал	94,727,800.00	94,727,800.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	9,971,300.00	9,011,299.34	960,000.66
210203	ҮОМШӨ даатгал	7,977,100.00	8,965,489.54	(988,389.54)
21204	Ажилгүйдлийн даатгал	1,994,300.00	1,965,911.12	28,388.88
210205	Эрүүл мэндийн даатгал	19,942,700.00	19,942,700.00	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,439,800.00</b>	<b>35,439,599.66</b>	<b>200.34</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,484,900.00	8,093,419.00	2,391,481.00
210302	Түлш, халаалт	16,450,500.00	20,547,000.14	(4,096,500.14)
210303	Цэвэр, бохир ус	8,504,400.00	6,799,180.52	1,705,219.48
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,358,500.00</b>	<b>14,313,580.00</b>	<b>44,920.00</b>
210401	Бичиг хэрэг	1,819,000.00	1,819,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	5,624,600.00	5,624,600.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,029,200.00	2,018,200.00	11,000.00
210404	Ном, хэвлэл	287,000.00	253,080.00	33,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	732,100.00	732,100.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,866,600.00	3,866,600.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>30,054,400.00</b>	<b>26,947,663.00</b>	<b>3,106,737.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,052,400.00	2,013,600.00	38,800.00
210502	Хоол, хүнс	26,157,000.00	23,089,063.00	3,067,937.00
210503	Нормын хувцас	1,845,000.00	1,845,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,184,600.00</b>	<b>5,184,600.00</b>	-
210604	Урсгал засвар	5,184,600.00	5,184,600.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,801,400.00</b>	<b>4,559,340.00</b>	<b>242,060.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	2,653,000.00	2,653,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,164,000.00	1,000,000.00	164,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	298,400.00	297,540.00	860.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	490,200.00	488,800.00	1,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	195,800.00	120,000.00	75,800.00
2109	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,094,200.00</b>	<b>7,094,180.00</b>	<b>20.00</b>
210901	Бараа, үйлчилгээний бусад зардал	3,405,600.00	3,405,600.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,688,600.00	3,688,580.00	20.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,765,800.00</b>	<b>35,674,713.00</b>	<b>12,091,087.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,429,800.00	31,615,132.00	11,814,668.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,336,000.00	4,059,581.00	276,419.00
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,316,446,800.00</b>	<b>1,300,961,775.66</b>	<b>15,485,024.34</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,316,446,800.00</b>	<b>1,300,961,775.66</b>	<b>15,485,024.34</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,316,446,800.00	1,300,961,775.66	15,485,024.34
<b>4</b>	<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-
<b>5</b>	<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>			
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>68</b>	<b>79</b>	<b>(11)</b>
610001	Удирдах ажилтан	1	1	-
610002	Гүйцэтгэх ажилтан	42	53	(11)
610003	Үйлчлэх ажилтан	25	25	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>1,106,393.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>1,106,393.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>629,393.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	198,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	198,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	431,393.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	-	431,393.00
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	-	<b>477,000.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	477,000.00
213303	Улсын төсвөөс санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	477,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>1,106,393.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>1,106,393.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	629,393.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	477,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	-
<b>IV</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>V</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулах, авлага, өглөгийн дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 21-ний хооронд Лидер экаунт аудит ХХК-ийн аудитор П.Шаравхорол, аудиторын туслах М.Мягмарсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Ш.Уянга хэрэгжүүлсэн.

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тайланг Лидер экаунт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн эрхэм зорилго нь “Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлж буй боловсролын үйлчилгээг чанаржуулж, суралцагчдын бодит чадвартай иргэн болгон төлөвшүүлэх”-д оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль үйл ажиллагаандаа дараах 4 зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах эрсдэлгүй орчин бүрдүүлэх
- Судлагдахуун бүрээр суралцагч нэг бүрийн ялгаатай байдалд тулгуурласан сурлагын чанарт ахиц гаргах
- Багшийн хөгжлийг хангах, харилцаа хандлагыг өөрчлөх
- Багшийн судалгаа шинжилгээний арга барилд суралцуулахад дэмжлэг үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сургуулийн захирлын 2021 оны Б/01 дүгээр тушаалаар Багш ажилчдын цалинтай холбоотой ажилласан жил, үндсэн цалин хөлс, зэрэглэл, албан тушаал, мөнгөн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох зэргийг шинэчлэн баталсан;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”.



Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг завсрын үеийн аудитаар сайжруулах зөвлөмж өгсний дагуу хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулан мөрдөж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,571,904.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 15,719.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 155,507.9 мянган төгрөгөөр буюу 7 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө болон өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-

Авлага	938.2	2,244.9	1,306.7
Урьдчилгаа	1,150.0	1,150.0	-
Бараа материал	87,125.1	85,396.0	(1,729.1)
Үндсэн хөрөнгө	2,250,472.3	2,095,386.8	(155,085.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,339,685.6</b>	<b>2,184,177.7</b>	<b>(155,507.9)</b>
Өр төлбөр	10,667.7	44,911.1	34,243.4
Засгийн газрын оролцоо/Цэвэр хөрөнгө өмч/	2,329,017.9	2,139,266.6	(189,751.3)
<b>Нийт өр төлбөр, ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,339,685.6</b>	<b>2,184,177.7</b>	<b>(155,507.9)</b>

Авлага дансны үлдэгдэл 2,244.9 мянган төгрөг болж, 1,306.7 мянган төгрөгөөр өссөн нь Япон улсын Daikhan Co.,Ltd компаниас брайль цаас худалдан авахаар 2,105.1 мянган төгрөгийг шилжүүлсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,095,386.8 мянган төгрөг болж, 155,085.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв ТББ-аас 110 ширхэг 3,358.6 мянган төгрөгийн ном, эд хөрөнгө, хандиваар 29,515.5 мянган төгрөгийн 13 ширхэг тоног төхөөрөмж хүлээн авсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны А-1/1596 тоот албан бичгийн дагуу ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 216 төрлийн 305,876.9 мянган төгрөгийн биет болон биет бус хөрөнгийг акталж, данснаас хассан.

Өр төлбөр дансны үлдэгдэл нь цалингийн өглөг 13,117.9 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 21,023.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 102.4 мянган төгрөг, нийт 34,243.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны нийт зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,276,446.8 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлуулсан байна.

Төсвийн тодотголоор санхүүжилтийн эх үүсвэрийг 1,316,446.8 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 1,316,446.8 мянган төгрөгийн зарцуулалтыг баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,316,446.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,316,446.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 1,300,961.8 мянган төгрөгийг зарцуулж, 98.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,300,961.8 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь хангамжийн зардал 44.9 мянган төгрөг, нормативт зардал 3,106.7 мянган төгрөг, бусдаар

гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 242.1 мянган төгрөг, нийт 3,393.6 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь санхүүжилтээр хэрэгжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагааны урсгал зардал 3,394.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардал 12,091.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт-2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Үзүүлэлт				
1	71807	Тусгай хэрэгцээт боловсрол	1,316,446.8	1,300,961.8	(15,485.0)	98.8
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	1,268,681.0	1,265,287.1	(3,394.0)	99.7
1.2	80102	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	47,765.8	35,674.8	(12,091.0)	74.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтсээс ариутгал, халдваргүйтэлд зориулан олгосон 629.4 мянган төгрөг, ажилтанд олгосон цалингийн буцаалт 477.0 мянган төгрөг нийт 1,106.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт орсон байна. Ариутгал, халдваргүйтлийн 629.4 мянган төгрөгнөөс 198.0 мянган төгрөгийг ариутгалын материалд, 431.4 мянган төгрөгийг нормативт зардалд зарцуулж, цалингийн буцаалт 477.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь харааны бэрхшээлтэй сурагчдад ерөнхий боловсрол олгодог бөгөөд Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/307/91/237 дугаар тушаалаар тусгай сургуулийн анги дүүргэлтийг батласны дагуу анги дүүргэлт нь сурагчдын тооноос хамаарч анги бүлэг нэмэгддэг байна. Сүүлийн 5 жилд харааны бэрхшээлтэй сурагчдын тоо өссөн боловч багш ажилчдын орон тоог 68 хүнээр баталж ирсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль нь нийт 1,362,408.5 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 34,147.0 мянган төгрөгийн 9 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль, өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 17,278.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илрүүлж, 3 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах зөвлөмж өгснийг биелүүлэн ажилласан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 516,461.8 мянган төгрөгийн 10 зөрчлөөс 358.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 278,660.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 221,538.4 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 96.9 хувьтай байна.

*Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилт /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	358.1	1	358.1	-	-	100.0
Албан шаардлага	4	294,565.3	3	278,660.7	1	15,904.6	94.6
Зөвлөмж	5	221,538.4	5	221,538.4	-	-	100.0
Нийт дүн	10	516,461.8	9	500,557.2	1	15,904.6	96.9

Ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий 3 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрт олгосон 15,904.6 мянган төгрөгийн төрд учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр төлүүлж, зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сүүлийн 5 жилд харааны бэрхшээлтэй сурагчдын тоо нэмэгдэхийн хирээр 6-12 насны хүүхдүүдтэй ажиллах багш ажилчдын орон тоо нэмэгдэж 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 79 хүн ажиллаж батлагдсан орон тооноос 11 хүнээр илүү байна.

Харааны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж байгаа багш нарын орон тоог нэмэгдүүлэх талаар Сангийн яам, Боловсрол шинжлэх ухааны яаманд 5 жил дараалан асуудлыг шийдвэрлүүлэхээр тавьж байгаа боловч шийдвэрлээгүй, орон тоог 68 хүнээр баталж ирсэн байна. Иймд багш ажилчдын орон тооны бүтцийн хэтрэлтийг дараагийн аудитаар авч үзнэ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 81,125.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 34,369.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 46,756.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

##### **4.1 Төлбөрийн акт**

Төлөвлөгдсөн цалингийн зардлаас ажлаас халагдсан ажилчдын шүүхийн шийдвэрийн нөхөн олговор 34,369.1 мянган төгрөгийг олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, УСНББОУС 11-ын нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий 3 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрт олгосон 34,369.1 төгрөгийн төрд учруулсан хохирлыг гэм буруутай дээр төлүүлж, зөрчлийг арилгах, төлбөрийн акт

##### **4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### **1. Авлага өглөгийн данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тайлагнагдсан 1,209.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж, ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

###### **2. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Тайлант онд аж ахуйн нэгжүүдээс 18,492.4 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдснийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт бүрийг цахим баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**3. Худалдан авалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Сурагчдын өдрийн цай болон дотуур байрны сурагчдын хоолны зардалд зориулан хүнсний материал худалдан авах 3 компанитай байгуулсан 27,054.5 мянган төгрөгийн гэрээг дүгнээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийсэн гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, гэрээ дүгнэсэн актыг үнэн зөв үйлдэж, үүргийн биелэлтийг дүгнэсний үндсэн дээр төлбөр тооцоог хийхэд анхаарч ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал																
1	Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль	АХГ-2022/41/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий 3 ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговор төсвөөс олгосон.	Төлөвлөгдсөн цалингийн зардлаас ажлаас халагдсан ажилчдын шүүхийн шийдвэрийн нөхөн олговор олгосон 34.369.1 мянган төгрөгийг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасны дагуу төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх.	1	34,369.1			1	34,369.1						
2	Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль	АХГ-2022/41/НА-СТА-ТШЗ	Тайланд тусгагдсан авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж, ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	1,209.8								1	1,209.8	
3	Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль	АХГ-2022/41/НА-СТА-ТШЗ	Анхан шатны хүчин төгөлдөр бус и-баримтгүй худалдан авалт хийсэн	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	18,492.4								1	18,492.4	



**Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

4	Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль	АХГ-2022/41/НА-СТА-ТШЗ	Сурагчдын өдрийн цай болон дотуур байрны сурагчдын хоолны зардал зориулан хүнсний материал худалдан авахаар 3 компанитай гэрээ байгуулсан гэрээг дүгнээгүй байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах"	1	27,054.5								1	27,054.5	
<b>Дүн</b>					<b>4</b>	<b>81,125.8</b>			<b>1</b>	<b>34,369.1</b>				<b>3</b>	<b>47,756.7</b>	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургууль	АХГ-2022/41/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 173 мэдээллээс 9 мэдээллийг байршуулаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг мөрдөж ажиллах	1	34,147.0				1	34,147.0	1	34,147.0			
<b>Дүн</b>					<b>1</b>	<b>34,147.0</b>				<b>1</b>	<b>34,147.0</b>	<b>1</b>	<b>34,147.0</b>			
<b>Нийт дүн</b>					<b>5</b>	<b>115,272.8</b>			<b>1</b>	<b>34,369.1</b>	<b>1</b>	<b>34,147.0</b>	<b>1</b>	<b>34,147.0</b>	<b>3</b>	<b>47,756.7</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 35/20150058

Улаанбаатар хот

АХГ-2022/41/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий 3 ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 34,369,198.00 төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Нэр бүхий 3 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрт олгосон 34,369,198.00 /гучин дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга нэг зуун ерэн найман/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
- Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн захирал Э.Нүрэд, нягтлан бодогч Б.Уламбаяр нарт хариуцуулав.

**АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

П.ШАРАВХОРОЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 220/А0150058  
АХГ-0002/41/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулах 173 мэдээллээс 34,147,023.00 төгрөгийн 9 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны тухай хууль, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нягтлан бодогч Б.Уламбаярт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг сургуулийн захирал Э.Нүрээдэд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

П.ШАРАВХОРОЛ





